

## **Багахангай дүүргийн хүн эмнэлэг**

Анх 1989 онд Бага-хангай дүүргийн хүн эмнэлэг байгуулагдсан. Одоо их эмч 4, сувилагч 5, эмнэлгийн дунд мэргэжилтэн 4, үйлчлэгч 5, туслах ажилтан 3 тогооч 1, нярав 1, жолооч 1 нийт 25 ажиллагсадтай түргэн тусламжийн автомашин 3, жилдээ нийт 150050,8 төгрөгийн төсөвтэй ажиллаж байна.

Эрхэм зорилго: Эмнэлгийн тусламж үйлчилгээг дүүргийн хүн амд жигд хүртээмжтэй чанартай стандартын дагуу үзүүлнэ.

2008 оны зорилт : Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж эмчлэн сэргийлэх тусламж үйлчилгээг боловсон шуурхай ил тод, соёлтой чанартай хүртээмжтэй стандартын дагуу иргэдэд үзүүлнэ.

### **Үндсэн чиглэл**

а/ Эрүүл мэндийн салбарын хөгжлийг хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах 2 талт үйл ажиллагаанд чиглүүлж, тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай хүргэх

б/ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түлхүү хөгжүүлэх

в/ Эрүүл мэндийн нэн тулгамдсан асуудал болох халдварт өвчин, эхийн эндэгдэл, шүд амны хөндийн өвчлөлийг бууруулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх эмчилгээ оношлог ооны чанарыг сайжруулах

г/ Эрүүл мэндийн салбарт шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж техник болон байраар хангах арга хэмжээг нийслэлийн дүүргийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд дэс дараатай тусгах

д/ Эрүүл хамт олон болон эрүүл хүн амыг дэмжихэд байгууллага иргэдийн идэвхтэй оролцоо үр дүнтэй хамтын ажиллагааг чиглүүлэх

е/ Өөрийн байгууллагын хүчин чадалд тохирсон эмчилгээ оношлог ооны болон нийтлэг ажил үйлчилгээний өвөрмөц стандарт технологийг боловсруулан мөрдөх

### **Дүүргийн хүн эмнэлгийн ололт амжилтын талаар:**

Одоо хамт олны дунд Монгол улсын эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан их эмч Л.Баядорж, вакцинаар сувилагч Ч.Туяа, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын тэргүүний ажилтан эмэгтэйчүүдийн их эмч Б.Мөнхжаргал сувилагч С.Цэдэвсүрэн, сувилагч Г.Сарангэрэл, 1994, 2000, 2005 онуудын дүүргийн хөдөлмөрийн аварга түргэний жолооч Ч.Бат-Эрдэнэ, 2004 оны дүүргийн хөдөлмөрийн аварга сувилагч Г.Сарангэрэл зэрэг сайчууд олноор төрөн ажиллаж байна.

### **Цаашдын зорилт:**

1. Дүүргийн хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчилсөн тохиолдолд эмчилж , эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.

2. 2010-2012 онд 60 ортой эмнэлэг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөгдсөн.

3. Лабораторийн багаж тоног төхөөрөмжөөр хангаж орон нутагтаа иж бүрэн лабораторитой болж үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй үйлчлэх
4. Эмийн бус эмчилгээг өргөтгөж, эмийн бус кабинет байгуулж, тоног төхөөрөмжөөр хангах
5. Хүүхдийн эндэгдлийг нарийн судалж эндэгдлийг бууруулах шинжлэх ухааны үнэтэй төлөвлөгөө боловсруулж ажиллана.
6. Халдварт өвчний гар алтанд судалгаа гаргаж, халдварт өвчин гарах үндсэн шалтгааныг арилгаж, халдварт өвчний гаралтыг бууруулах.